



### ОНЦЛОХ МЭДЭЭ:

- Монгол Улсаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурч байхад гадаадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын богино позиц нэмэгдэхэд нөлөөлжээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл 22.6 тэрбум ам.доллар байна.

### Төлбөрийн тэнцэл

2016 оны 1-р улиралд урсгал данс 11 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 141 сая долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 38 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурчээ. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -168 сая ам.доллар байна.

2015 оны 1-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 17 сая ам.доллараар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн данс 177 сая ам.доллараар сайжирсан байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,546.3 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

#### Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




### Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,561 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 28,664 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2016 оны 1-р улирлын байдлаар 25,103 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах ба богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 4% буюу 1037 сая ам.доллараар өссөн.

Үүнд, багцын хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалт болон шууд хөрөнгө оруулалтын богино позицууд 118 сая ам.доллар, 565 сая ам.доллар, 294 сая ам.доллараар тус тус өсч, гадаад валютын улсын нөөц 59 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

#### Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц



### АГУУЛГА


Төлбөрийн тэнцэл	2
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	4
Нийт гадаад зээл	6
Хавсралт	7

### Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 22,599 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 1,614 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрийн гадаад өр 14%-иар буюу 480 сая ам.доллараар өсч 4,036 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 11%-иар буюу 208 сая ам.доллараар өсч 2,084 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 30%-иар буюу 481 сая ам.доллараар өсч 2,061 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 4%-иар буюу 122 сая ам.доллараар өсч 3,568 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 3%-иар буюу 322 сая ам.доллараар өсч 10,850 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

#### Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



### Судалгаа, статистикийн газрын Статистикийн хэлтэс

Монголбанк  
Бага тойруу 3,  
Улаанбаатар 15160  
Утас: 976-11-323243,  
327088

Факс: +976-11-327088  
Email:  
bor@mongolbank.mn

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## УРСГАЛ ДАНС

2016 оны 1-р улиралд урсгал тэнцлийн алдагдал 11 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2015 оны мөн үеэс 61%-иар буурчээ.

Бараа, үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 43 сая ам.доллараар буурсан нь барааны гадаад худалдааны ашиг 21 сая ам.доллараар буурч, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 22 сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 13%-иар буурч 1,476 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд 410.2 сая ам.долларт хүрч, сүүлийн 9 улирал дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад нефтийн импорт 10%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 9%-иар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн өнгөрсөн оны мөн үед 7% хүрч буурч байсан хэрэглээний барааны импорт тайлант хугацаанд 3%-иар буурсан байна.

## Үйлчилгээний худалдаа

Тайлант улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны 1-р улирлын гүйцэтгэлээс 9%-иар өсч 272 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 23%-иар буюу 34 сая ам.доллараар өссөн нь голчлон нөлөөлжээ. Бусад үйлчилгээний зардал өсөхөд санхүүгийн, тээврийн хэрэгслийн түрээсийн, архитектур, инженер болон техникийн үйлчилгээний өсөлт голчлон нөлөөлжээ.

## Орлого

2016 оны 1-р улирлын гүйцэтгэлээр орлогын данс 194 сая ам.долларын алдагдалтай гарч 2015 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 13%-иар буюу 29 сая ам.доллараар буурсан. Тайлант хугацааны голлох төлбөрийг дурьдвал:

- ААНБ-ууд гадаадын хөрөнгө оруулагчдад 38 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 113 сая ам.долларын хүү төлсөн,
- Монгол Улсын Засгийн газар гадаад зээлийн эх үүсвэрт 7 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- ААНБ-ууд бусад гадаад зээлийн эх үүсвэрт 29 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 9 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Төр, хувийн хэвшил хамтдаа бондын эх үүсвэрт 33 сая долларын хүүгийн төлбөрийг төлсөн байна.


## Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 31%-иар өссөн, гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 36%-иар буурснаар ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 27 сая ам.доллар болж 11 дахин өссөн байна.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	I улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
<b>I. Урсгал тэнцэл</b>	<b>-28</b>	<b>-11</b>	<b>17</b>	<b>61%</b>
<b>A. Бараа, үйлчилгээний худалдаа</b>	<b>180</b>	<b>138</b>	<b>-43</b>	<b>-24%</b>
a. Бараа	431	410	-21	-5%
б. Үйлчилгээ	-251	-272	-22	-9%
<b>B. Цэвэр орлого</b>	<b>-223</b>	<b>-194</b>	<b>29</b>	<b>13%</b>
<b>B. Урсгал шилжүүлэг</b>	<b>14</b>	<b>45</b>	<b>31</b>	<b>216%</b>

Дүрслэл 4. Барааны худалдаа



Дүрслэл 5. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	18,080	36% ▲	48%	2,012	9% ▼	-12%
Америк	5,695	11% ▲	14%	3,807	16% ▼	-55%
Хятад	3,586	7% ▲	35%	4,880	21% ▼	-27%
Гонг Конг	1,803	4% ▲	39%	973	4% ▼	-69%
Англи	1,827	4% ▼	-39%	875	4% ▼	-15%
ОХУ	1,024	2% ▼	-14%	1,953	8% ▲	29%
Сингапур	584	1% ▼	-18%	1,841	8% ▲	154%
Швейцарь	382	1% ▼	-79%	109	0% ▼	-95%
Герман	1,194	2% ▼	-7%	419	2% ▼	-42%
Япон	1,515	3% ▲	119%	618	3% ▼	-33%
Бусад	14,919	29% ▲	68%	5,708	25% ▼	-35%
<b>НИЙТ</b>	<b>50,607</b>	<b>100%</b>		<b>23,195</b>	<b>100%</b>	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)

	I улирал			Өөрчлөлт	
	2014	2015	2016	Мөнгөн дүн	Хувиар
<b>Ажилчдын гуйвуулга (цэвэр)</b>	<b>11.2</b>	<b>2.5</b>	<b>27.4</b>	<b>24.9</b>	<b>981.6%</b>
<b>Гаднаас орж ирсэн</b>	<b>49.3</b>	<b>38.6</b>	<b>50.6</b>	<b>12.0</b>	<b>31.0%</b>
<b>Гадагш шилжүүлсэн</b>	<b>-38.2</b>	<b>-36.1</b>	<b>-23.2</b>	<b>12.89</b>	<b>-35.7%</b>

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 141 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 177 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм.

Энэ нь Монгол Улсад орох шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт цэвэр дүнгээрээ өнгөрсөн оны мөн үеэс 278 сая ам.доллараар өссөнөөр тайлбарлагдаж байна.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2016 оны 1-р улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 165 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 278 сая ам.доллараар өссөн байна.

Үүнд, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн оны түвшнээс 309 сая ам.доллараар нэмэгдэж, 174 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл, БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 147%-иар буурч 14.4 сая ам.долларт, БНСУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 96%-иар буурч 0.35 сая ам.долларт хүрсэн бол Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 35%-иар өсч 16.3 сая ам.долларт хүрсэн байна.

Эдийн засгийн салбараар нь авч үзвэл уул уурхайн салбарт нийт хөрөнгө оруулалтын 38.9% (64.7 сая ам.доллар), бөөний болон жижиглэн худалдааны салбарт 24.6% (41 сая ам.доллар), үйлчилгээний бусад салбарт 9.4% (15.6 сая ам.доллар), цахилгаан, хий, уур, агааржуулалтад 9.1% (15.2 сая ам.доллар), мэргэжлийн шинжлэх ухаан, технологийн салбарт 5.7% (9.5 сая ам.доллар) нь тус тус хамаарч байна.

Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 68%-иар, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 17%-иар, үйлчилгээний бусад салбар 14%-иар, цахилгаан хий, агааржуулалтын болон мэргэжлийн шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааны салбарын хөрөнгө оруулалт 5% тус тус өссөн байна.

Харин санхүү, даатгалын үйл ажиллагаа, барилга, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа болон бусад салбарт оруулсан хөрөнгө оруулалтууд өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.

### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 13 сая ам.долларын алдагдалтай буюу алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 6 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

### Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 32 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тэнцэл 95 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	I улирал		Өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
<b>II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл</b>	<b>-36</b>	<b>141</b>	<b>177</b>	<b>491%</b>
<b>A. Хөрөнгийн данс</b>	<b>22</b>	<b>21</b>	<b>-1</b>	<b>-3%</b>
<b>B. Санхүүгийн данс</b>	<b>-58</b>	<b>120</b>	<b>178</b>	<b>-308%</b>
a. Шууд хөрөнгө оруулалт	-114	165	278	245%
Гадагш хийсэн	-2	-2	0	-2%
Монгол Улсад орсон	-112	166	278	249%
б. Багцын хөрөнгө оруулалт	-7	-13	-6	-92%
в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	0	24%
г. Бусад хөрөнгө оруулалт	63	-32	-95	-150%
Үүнээс: Худалдааны зээл	-114	-53	61	53%
Бэлэн мөнгө харилцах	163	205	42	0

Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	I улирал		2016/15	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	БНХАУ	14.4	9%	-147%	▼
2	Өмнөд солонгос	0.4	0%	-96%	▼
3	Канад	3.0	2%	-1959%	▼
4	Гонг Конг	27.1	16%	-934%	▼
5	Япон	16.3	10%	35%	▲
6	ОХУ	-2.2	-1%	-32%	▼
7	Англи	5.9	4%	-292%	▼
8	АНУ	-1.2	-1%	-112%	▼
9	Люксембург	6.6	4%	20%	▲
10	Австрали	125.9	76%	-407%	▼
11	ХБНГУ	-3.0	-2%	-660%	▼
12	Сингапур	-28.8	-17%	333%	▲
13	Бусад	2.3	1%	-104%	▼
<b>Нийт</b>		<b>166.4</b>	<b>100%</b>		

Дүрслэл 6. ГШХО, ЭЗ-ийн салбараар (сая ам.доллар)



## Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт -168 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалын төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

## II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2016 оны 1-р улирлын эцэст -25,103.4 сая ам.доллар байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 25.1 тэрбум ам.доллараар их байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,560.9 сая ам.доллар байна. Үүний 47%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 36%-ийг гадаад валютын улсын нөөц, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 7%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 28,664.3 сая ам.долларт хүрчээ. Үүний 59%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 31%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 10%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36%-ийг буюу 5,972.4 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 64% буюу 10,849.6 сая ам.долларыг эдийн засгийн харьяат компанийн гадаад дахь толгой компаниасаа авсан зээл эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх улирлаас 2%-иар буюу 402.9 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 10%-иар буюу 330.6 сая ам.доллараар, гадаад пассив 2.6 %-иар буюу 733.5 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 1%-иар буюу 145.6 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 9.4 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 3%-иар буюу 190.2 сая ам.доллараар өсч, ГВУН 4%-иар буюу 57.9 сая ам.доллараар тус тус буурснаар,
- Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 157.8 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 35.4 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр -210.1 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 66.7 сая ам.доллараар өөрчлөгдсөнөөр тус тус тайлбарлаж байна.

2012 оны эцсээс эхлэх гадаад активын дүн буурч байгаа нь гадаад валютын улсын нөөцийн бууралтаас шалтгаалсан бол гадаад пассив өсөлт нь бусад хөрөнгө оруулалтын тодруулбал ААН-үүд болон Хөгжлийн банкны гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлттөөр голчлон тайлбарлагдаж байна.


### Гадаад секторын статистик

Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг. Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.


Хүснэгт 6. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2015	3/31/2016	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-24,061	-25,103	1,043	4%
<b>I. Гадаад актив</b>	<b>3,000</b>	<b>3,561</b>	561	19%
1. Шууд хөрөнгө оруулалт	367	378	11	3%
2. Багцын хөрөнгө оруулалт	288	239	-49	-17%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	1	13	12	900%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,019	1,665	646	63%
5. Нөөц актив	1,324	1,265	-59	-4%
<b>II. Гадаад пассив</b>	<b>27,060</b>	<b>28,664</b>	<b>1,604</b>	<b>6%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	16,607	16,822	215	1%
2. Багцын хөрөнгө оруулалт	2,906	2,975	69	2%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	4	18	13	292%
4. Бусад хөрөнгө оруулалт	7,543	8,850	1,307	17%

Дүрслэл 7. Гадаад актив



Дүрслэл 8. Гадаад пассив



Дүрслэл 9. Статистик хамаарал

		Төлбөрийн тэнцэл (BOP)	
		Урсгал ба хөрөнгийн данс	
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)	IIP (Хугацааны эхэнд)	Санхүүгийн данс	Дахин үнэлгээ /Үнэ, ханш, бусад/
			IIP (Хугацааны эцэст)
		Алдаа ба оржигдуулга	

## Багцын хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад актив 2016 оны 1-р улирлын эцэст 239.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 17%-иар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 2,974.8 сая ам.долларт хүрч 2%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Актив:** эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл, Гонг конг 67%, Австрали 12%, АНУ 6%, Сингапур 5%, БНХАУ 3%, Канад 3%, Их Британи 2%, Швейцарь 1%, Солонгос 1%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал, Сингапур улс 22%, Гонг конг 15%, Япон улс 3%, АНУ 1%, бусад улс 3%, үлдсэн 56% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул аль улсын эдийн засгийн харьяат эзэмшиж буйг тодорхойлох боломжгүй байна.

## Компаниудын хувьцааны үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэ 2016 оны 1-р улиралд өмнөх жилийн мөн үеийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 35%-иар буурчээ. Тодруулбал,

**Өссөн:** Винсвэй Кокинг кол компанийн хувьцааны үнэ 71%-иар өсч 0.4 гонг конг долларт хүрсэн.

**Буурсан:** Монголиа Майнинг корпорацийн хувьцааны үнэ 84%-иар, Саусгови ресурс 74%-иар, Пропеси кол 70%-иар, Петро матад 61%-иар, Харанга ресурс 57%-иар, Оюутолгой 19%-иар, Писс мап холдинг 13%-иар, Сентерра гоулд 2.4%-иар буюу түүхий эд олборлогч компаниудын хувьцааны үнэ их хэмжээгээр, үнэт металл орлоглогч компаниудын хувьцааны үнэ харьцангуй бага хувиар буурсан байна.

## Засгийн газрын бондын үнэ

Хөгжиж буй болон бүрэлдэж буй эдийн засагтай улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн супер мөчлөг дуусгавар болсон нь хөгжиж буй орнууд тэр дундаа уул уурхайн салбараас өндөр хамааралтай орнуудад томоохон сорилтыг бий болгосон.

2016 оны 2 сард бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн индекс (CRB) өмнөх оны мөн үеэс 30.1%-иар буурч, үүнийг дагаад Засгийн газрын 5 жилийн хугацаатай бондын үнэ 7.4%, 10 жилийн хугацаатай бондын үнэ 16.2%-иар тус тус буурсан. Харин 2016 оны 3 дугаар сард түүхий эдийн үнэ бага зэрэг тогтворжиж, гадаад зах зээлд үүссэн тодорхой бус байдал аажмаар арилахад Засгийн газрын бондын үнэ ялимгүй өсөх хандлага ажиглагдсан.

Бондын өгөөжийн муруй нь дээрх хамаарлыг батлах бөгөөд тодруулбал, Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 2016 оны 2 сард хамгийн ихдээ 13.3%, 10 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 11.9%, Хөгжлийн банкнаас 5 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 15.9% Дим Сам бондын өгөөж 2016 оны 3 сард 16.6%, -д тус тус хүрч байсан (эрсдэл өссөнийг илэрхийлнэ) бол 2016 оны 3-р сарын эцэст харгалзан 9.1%, 9.7%, 9.0%, 15.5% хувь болж буураад байна.

Хүснэгт 7. Багцын ХО-ын позиц(пассив), сая ам.доллар


№	Улс	2012	2013	2014	2015*	2016/1*
1	Австрали	6	0	3	4	4
2	Кайманы арлууд	6	0	1	2	2
3	Гонг Конг	471	323	442	453	456
4	БНХАУ	3	4	13	7	7
5	Япон	3	1	254	94	95
6	БНСУ	4	1	3	3	3
7	Люксембург	2	4	13	7	7
8	Сингапур	576	581	584	637	642
9	АНЭУ	2	4	4	3	3
10	Их Британи	3	2	4	3	3
11	АНУ	-	40	70	40	40
12	Тодорхойгүй/ Нууцлалтай	1,531	1,500	1,501	1,659	1,670
13	Бусад	83	10	23	42	43
<b>Нийт дүн</b>		<b>2,689</b>	<b>2,470</b>	<b>2,913</b>	<b>2,956</b>	<b>2,975</b>

\* Урьдчилсан гүйцэтгэлээр

Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ


№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					3/31/2015	3/31/2016	
1	Turquoise Hill Resources	TRQ.US	US	USD	3.12	2.54	-19% ▼
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.28	0.05	-84% ▼
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	6.18	6.03	-2% ▼
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	5.67	1.50	-74% ▼
5	Winsway Coking Coal	1733.HK	HK	HKD	0.23	0.40	71% ▲
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.34	0.19	-44% ▼
7	Petro Mатад	MATD.L	LN	GBP	5.75	2.23	-61% ▼
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.02	-70% ▼
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.01	0.00	-57% ▼
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.27	0.23	-13% ▼

Дүрслэл 10. ЗГ-н бондын үнэ, Түүхий эдийн үнийн индекс



\* 2015 оны 6-р сарын 26 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.

Дүрслэл 11. МУ-н ЗГ-н бондуудын өгөөжийн муруй



\* 2015 оны 6-р сарын 26 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.  
\*\* CRB index - 22 нэр төрлийн бараа, түүхий эдийн үнэс бүрдсэн индекс.

## IV. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны 1-р улирлын байдлаар 22,599 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1,614 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Энэхүү өсөлтийн 30%-ийг Засгийн газрын гадаад өр, 13%-ийг Төв банкны гадаад өглөг, 30%-ийг банкуудын гадаад өр, 8%-ийг бусад сектор (аж ахуйн нэгж, иргэд, Хөгжлийн банк)-ын гадаад өр, 20%-ийг гадаадын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгжийн эдийн засгийн харьяат бус толгой компаниасаа авсан зээлийн өсөлт тус тус тайлбарлаж байна.

### Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2016 оны 1 дүгээр улирлын эцэст 2,061 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 30%-иар буюу 481 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 41%-ийг урт хугацаат зээл, 31%-ийг бонд, өрийн бичиг, 17%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 11%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 8 сая ам.долларын урт хугацаат, 54 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, гэрээний дагуу 55 сая ам.долларын урт, 32 сая ам.долларын богино хугацаат зээлийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл харгалзан 835 сая ам.доллар, 353 сая ам.долларт тус тус хүрчээ.

### Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2016 оны 1-р улирлын эцэст 14,418 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 444 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 75% буюу 10,850 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай.


Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг авч үзвэл тайлант онд харгалзан 242 сая ам.доллар, 68 сая ам.доллар байжээ.

ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 476 сая ам.доллар болсон байна.


Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2015	3/31/2016	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт гадаад өр</b>	<b>20,985</b>	<b>22,599</b>	<b>1,614</b>	<b>8%</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>3,556</b>	<b>4,036</b>	<b>480</b>	<b>14%</b>
<b>II. Төв банк</b>	<b>1,876</b>	<b>2,084</b>	<b>208</b>	<b>11%</b>
<b>III. Банк</b>	<b>1,579</b>	<b>2,061</b>	<b>481</b>	<b>30%</b>
Богино хугацаат	290	353	63	22%
Урт хугацаат	1,289	1,707	418	32%
<b>IV. Бусад сектор</b>	<b>3,446</b>	<b>3,568</b>	<b>122</b>	<b>4%</b>
Богино хугацаат	486	408	-79	-16%
Урт хугацаат	2,960	3,161	201	7%
<b>V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл</b>	<b>10,528</b>	<b>10,850</b>	<b>322</b>	<b>3%</b>

Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



### Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	1 дүгээр улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2014	2015	2016	Дүн	2015/14	Дүн	2016/15
<b>I. Урсгал Тэнцэл</b>	<b>-518</b>	<b>-28</b>	<b>-11</b>	<b>489</b>	<b>-95%</b>	<b>17</b>	<b>-61%</b>
<b>A. Бараа ба үйлчилгээний худалдаа</b>	<b>-390</b>	<b>180</b>	<b>138</b>	<b>571</b>	<b>-146%</b>	<b>-43</b>	<b>-24%</b>
<b>1. Бараа</b>	<b>72</b>	<b>431</b>	<b>410</b>	<b>359</b>	<b>496%</b>	<b>-21</b>	<b>-5%</b>
1.1 Ерөнхий эд бараа	20	340	301	321	1622%	-39	-11%
Экспорт Ф.О.Б. (Кредит)	897	967	832	70	8%	-136	-14%
Үүнээс: Зэсийн баяжмал	349	512	482	163	47%	-31	-6%
Импорт Ф.О.Б. (Дебит)	-877	-627	-530	250	-29%	96	-15%
Үүнээс: Нефлийн	-223	-154	-86	69	-31%	68	-44%
Хүнсний	-100	-84	-89	15	-15%	-4	5%
1.2 Мөнгөжөөгүй алт	90	98	111	8	9%	13	14%
Кредит	90	98	111	8	9%	13	14%
Дебит	0	0	0	0	0%	0	0%
1.3 Бусад	-37	-7	-2	30	-80%	5	-66%
Кредит	1	0	0	-1	-100%	0	-100%
Дебит	-38	-7	-2	31	-81%	5	-66%
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-463</b>	<b>-251</b>	<b>-272</b>	<b>212</b>	<b>-46%</b>	<b>-22</b>	<b>9%</b>
2.1 Тээвэр	-108	-60	-50	48	-44%	10	-16%
Кредит	45	45	40	0	0%	-5	-11%
Дебит	-153	-105	-91	48	-31%	14	-14%
2.2 Аялал	-110	-86	-84	24	-22%	2	-2%
Кредит	19	23	24	3	18%	2	9%
Дебит	-129	-108	-108	21	-16%	0	0%
2.3 Бусад үйлчилгээ	-245	-105	-139	140	-57%	-33	32%
Кредит	45	46	47	1	3%	1	2%
Дебит	-290	-151	-185	139	-48%	-34	23%
<b>B. Орлого</b>	<b>-171</b>	<b>-223</b>	<b>-193.9</b>	<b>-52</b>	<b>30%</b>	<b>29</b>	<b>-13%</b>
1. Ажиллагсдын цалин хөлс	-20	-10	-17	10	-51%	-7	67%
Кредит	15	12	11	-3	-20%	-1	-12%
Дебит	-35	-22	-27	13	-38%	-5	24%
2. Хөрөнгө оруулалтын орлого	-151	-213	-177	-62	41%	36	-17%
Кредит	1	1	2	0	22%	1	63%
Дебит	-152	-214	-179	-62	41%	35	-16%
<b>C. Урсгал шилжүүлэг (цэвэр)</b>	<b>44</b>	<b>14</b>	<b>45</b>	<b>-29</b>	<b>-67%</b>	<b>31</b>	<b>216%</b>
Кредит	85	52	71	-33	-38%	19	36%
Дебит	-41	-38	-26	3	-8%	12	-31%
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	11	3	27	-9	-77%	25	982%
Кредит	49	39	51	-11	-22%	12	31%
Дебит	-38	-36	-23	2	-5%	13	-36%
<b>II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл</b>	<b>385</b>	<b>-36</b>	<b>141</b>	<b>-421</b>	<b>-109%</b>	<b>177</b>	<b>-491%</b>
<b>A. Хөрөнгийн данс</b>	<b>24</b>	<b>22</b>	<b>21</b>	<b>-2</b>	<b>-10%</b>	<b>-1</b>	<b>-3%</b>
<b>B. Санхүүгийн данс</b>	<b>361</b>	<b>-58</b>	<b>120</b>	<b>-419</b>	<b>-116%</b>	<b>178</b>	<b>-308%</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>279</b>	<b>-114</b>	<b>165</b>	<b>-393</b>	<b>-141%</b>	<b>278</b>	<b>-245%</b>
1.1 Гадагш хийсэн	-4	-2	-2	2	-54%	0	-2%
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-4	-2	-2	2	-46%	0	-7%
1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	0	0	0	0	0%	0	0%
1.1.3 Бусад хөрөнгө	0	0	0	1	0%	0	0%
1.2 Монголд орсон	283	-112	166	-395	-139%	278	-249%
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	55	67	59	12	21%	-8	-11%
1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	-106	-43	-67	63	-59%	-24	55%
1.2.3 Бусад хөрөнгө	335	-135	174	-470	-140%	309	-228%
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>384</b>	<b>-7</b>	<b>-13</b>	<b>-391</b>	<b>-102%</b>	<b>-6</b>	<b>89x</b>
2.1 Актив	-6	-8	-2	-2	27%	6	-73%
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-6	-8	-2	-2	28%	5	-72%
2.1.2 Өрийн бичиг	0	0	0	0	-22%	0	-105%
2.2 Пассив	390	1	-11	-389	-100%	-12	-1047%
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	-2	2	0	4	-199%	-2	-99%
2.2.2 Өрийн бичиг	392	-1	-11	-393	619x	-10	1252%
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0%</b>
3.1 Актив	0	7	-5	8	0%	-13	0%
3.2 Пассив	1	-8	5	-8	0%	13	0%
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>-302</b>	<b>63</b>	<b>-32</b>	<b>365</b>	<b>-121%</b>	<b>-95</b>	<b>-150%</b>
4.1 Актив	-442	-69	-494	373	-84%	-425	619%
4.1.1 Худалдааны зээл	-129	18	-59	147	-114%	-78	-429%
4.1.2 Зээл	0	0	-12	0	2734%	-11	2578%
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-313	-86	-423	227	-72%	-336	389%
4.1.4 Бусад актив	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	140	132	462	-8	-6%	330	251%
4.2.1 Худалдааны зээл	-3	-133	6	-129	4016%	139	-105%
4.2.2 Зээл	138	-15	283	-154	-111%	298	-1956%
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	5	291	205	287	-32x	-86	-30%
4.2.4 Бусад пассив	0	-12	-32	-12	0%	-20	0%
<b>III. Алдаа болон орхигдуулга</b>	<b>-175</b>	<b>-207</b>	<b>-168</b>	<b>-32</b>	<b>18%</b>	<b>39</b>	<b>-19%</b>
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	<i>-308</i>	<i>-271</i>	<i>-38</i>	<i>37</i>	<i>233</i>	<i>233</i>	<i>-86%</i>
<b>IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*</b>	<b>308</b>	<b>271</b>	<b>38</b>	<b>-37</b>	<b>-12%</b>	<b>-233</b>	<b>-86%</b>
<b>1. Актив</b>	<b>332</b>	<b>274</b>	<b>38</b>	<b>-58</b>	<b>(0.17)</b>	<b>-236</b>	<b>-86%</b>
1.1 Мөнгөжсөн алт	39	0	0	-39	(1.00)	0	
1.2 Зээлжих тусгай эрх	0	0	0	0	(0.92)	0	-94%
<b>1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	
1.4 Бэлэн валют ба харилцах	292	274	38	-18	(0.06)	-236	-86%
1.5 Бусад нөөц актив	0	0	0	0		0	
<b>2. Пассив</b>	<b>-24</b>	<b>-3</b>	<b>0</b>	<b>21</b>	<b>(0.89)</b>	<b>3</b>	<b>-100%</b>
2.1 ОУВС-ийн зээл	-24	-3	0	21	(0.89)	3	-100%
2.2 Онцгой санхүүжилт	0	0	0	0		0	

\* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

Эх сурвалж: Монголбанк

**ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)**

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016
<b>Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)</b>	<b>-14,219</b>	<b>-20,440</b>	<b>-23,689</b>	<b>-24,066</b>	<b>-24,284</b>	<b>-24,488</b>	<b>-24,701</b>	<b>-25,103</b>
<b>I. Гадаад актив</b>	<b>6,380</b>	<b>4,005</b>	<b>3,437</b>	<b>2,999</b>	<b>3,660</b>	<b>3,240</b>	<b>3,230</b>	<b>3,561</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>	<b>1,191</b>	<b>258</b>	<b>355</b>	<b>367</b>	<b>375</b>	<b>376</b>	<b>382</b>	<b>378</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	1,191	252	348	360	366	364	369	365
1.1.1 Салбар компаниас авах	1,191	252	348	360	366	364	369	365
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	1	6	7	7	10	12	13	13
1.2.1 Салбар компаниас авах	1	6	7	7	10	12	13	13
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>106</b>	<b>387</b>	<b>280</b>	<b>288</b>	<b>315</b>	<b>251</b>	<b>235</b>	<b>239</b>
2.1 Хөрөнгийн хувьцаа	101	379	205	213	246	218	202	206
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
2.1.3 Банкууд	0	0	0	0	3	3	3	3
2.1.4 Бусад салбар	101	379	205	213	243	215	199	203
2.2 Өрийн бичиг	5	9	75	76	70	33	33	33
2.2.1 Бонд, үнэт цаас	0	0	52	52	52	15	15	15
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	0	0	0	0	0	1	1	1
2.2.1.4 Бусад салбар	0	0	52	52	52	14	15	15
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	4	8	24	24	18	18	18	18
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	4	8	24	24	18	18	18	18
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>13</b>	<b>8</b>	<b>13</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	9	1	2	13	8	13
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>957</b>	<b>1,112</b>	<b>1,144</b>	<b>1,019</b>	<b>1,281</b>	<b>1,188</b>	<b>1,283</b>	<b>1,665</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>384</b>	<b>540</b>	<b>566</b>	<b>535</b>	<b>611</b>	<b>516</b>	<b>607</b>	<b>666</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	384	540	566	535	611	516	607	666
Урт хугацааны	54	5	4	4	5	4	4	4
Богино хугацааны	329	534	562	531	606	512	603	662
<b>4.2 Зээл</b>	<b>15</b>	<b>5</b>	<b>51</b>	<b>51</b>	<b>52</b>	<b>53</b>	<b>52</b>	<b>64</b>
4.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	15	2	49	50	50	51	51	63
Урт хугацааны	0	0	45	45	46	46	47	47
Богино хугацааны	15	2	4	4	4	4	4	16
4.2.4 Бусад салбар	0	3	2	2	2	2	1	1
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	3	2	2	2	2	1	1
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>558</b>	<b>567</b>	<b>527</b>	<b>433</b>	<b>618</b>	<b>619</b>	<b>623</b>	<b>935</b>
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	530	494	315	299	430	474	441	613
4.3.4 Бусад салбар	29	73	212	134	188	146	182	323
<b>4.4 Бусад актив</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
4.4.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
<b>5. Нөөц актив</b>	<b>4,126</b>	<b>2,248</b>	<b>1,650</b>	<b>1,324</b>	<b>1,686</b>	<b>1,413</b>	<b>1,323</b>	<b>1,265</b>



Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016
<b>II. Гадаад пассив</b>	<b>20,599</b>	<b>24,445</b>	<b>27,127</b>	<b>27,066</b>	<b>27,944</b>	<b>27,728</b>	<b>27,931</b>	<b>28,664</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	<b>13,458</b>	<b>15,729</b>	<b>16,693</b>	<b>16,517</b>	<b>16,575</b>	<b>16,512</b>	<b>16,680</b>	<b>16,822</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972
1.2 Бусад хөрөнгө	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>2,689</b>	<b>2,470</b>	<b>2,913</b>	<b>2,906</b>	<b>3,590</b>	<b>3,043</b>	<b>2,961</b>	<b>2,975</b>
<b>2.1 Хөрөнгийн хувьцаа</b>	<b>113</b>	<b>35</b>	<b>94</b>	<b>87</b>	<b>94</b>	<b>82</b>	<b>84</b>	<b>76</b>
2.1.1 Банкууд	0	0	11	11	11	11	11	11
2.1.2 Бусад салбар	113	35	83	76	83	71	73	65
<b>2.2 Өрийн бичиг</b>	<b>2,576</b>	<b>2,435</b>	<b>2,819</b>	<b>2,819</b>	<b>3,496</b>	<b>2,961</b>	<b>2,877</b>	<b>2,899</b>
2.2.1 Бонд, үнэт цаас	2,576	2,435	2,819	2,819	3,494	2,959	2,875	2,897
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	2,080	2,080	1,500	1,500	1,685	1,460	1,418	1,395
2.2.1.3 Банкууд	495	351	473	472	959	668	649	643
2.2.1.4 Бусад салбар	1	4	847	847	851	831	808	859
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0	0	0	0	2	2	2	2
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	0	0	0	0	2	2	2	2
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>12</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>16</b>	<b>13</b>	<b>18</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	12	4	6	16	13	18
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>4,452</b>	<b>6,246</b>	<b>7,508</b>	<b>7,639</b>	<b>7,773</b>	<b>8,157</b>	<b>8,277</b>	<b>8,850</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>252</b>	<b>511</b>	<b>594</b>	<b>438</b>	<b>538</b>	<b>455</b>	<b>470</b>	<b>476</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	252	511	594	438	538	455	470	476
Урт хугацааны	31	339	291	212	358	282	302	307
Богино хугацааны	221	173	303	226	180	173	167	168
<b>4.2 Зээл</b>	<b>3,621</b>	<b>4,427</b>	<b>5,165</b>	<b>5,187</b>	<b>5,199</b>	<b>5,308</b>	<b>5,626</b>	<b>6,021</b>
4.2.1 Төв банк	78	75	71	68	69	68	68	68
ОУВС-гийн зээл	78	75	71	68	69	68	68	68
Бусад урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641
Урт хугацааны	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	337	629	904	902	890	936	1,106	1,080
Урт хугацааны	279	429	589	611	613	713	775	727
Богино хугацааны	58	200	315	290	277	223	331	353
4.2.4 Бусад салбар	1,023	1,538	2,081	2,162	2,183	2,222	2,221	2,232
Урт хугацааны	735	1,305	1,822	1,901	1,912	1,976	1,982	1,994
Богино хугацааны	288	233	259	261	271	246	239	237
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>142</b>	<b>160</b>	<b>1,589</b>	<b>1,877</b>	<b>1,921</b>	<b>2,183</b>	<b>1,954</b>	<b>2,157</b>
4.3.1 Төв банк	0	0	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	142	160	140	104	151	140	182	229
4.3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0
<b>4.4 Бусад пассив</b>	<b>436</b>	<b>1,147</b>	<b>160</b>	<b>138</b>	<b>114</b>	<b>212</b>	<b>228</b>	<b>196</b>
4.4.1 Төв банк	336	990	48	36	12	100	120	88
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	336	990	48	36	12	100	120	88
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	100	157	112	102	102	112	108	108
Урт хугацааны	100	157	112	102	102	112	108	108
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0

Эх сурвалж: Монголбанк

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)**

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016
<b>1. Засгийн газар</b>	<b>3,684</b>	<b>3,684</b>	<b>3,610</b>	<b>3,556</b>	<b>3,741</b>	<b>3,542</b>	<b>3,648</b>	<b>4,036</b>
<b>1.1 Богино хугацаат</b>	0	0	0	0	0	0	0	0
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/								
<b>1.2 Урт хугацаат</b>	3,684	3,684	3,610	3,556	3,741	3,542	3,648	4,036
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	1,500 2,184	1,500 2,184	1,500 2,110	1,500 2,056	1,685 2,057	1,460 2,081	1,418 2,230	1,395 2,641
<b>2. Төвбанк</b>	<b>415</b>	<b>1,065</b>	<b>1,568</b>	<b>1,876</b>	<b>1,851</b>	<b>2,211</b>	<b>1,960</b>	<b>2,084</b>
<b>2.1 Богино хугацаат</b>	337	990	1,497	1,809	1,783	2,143	1,892	2,016
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	337	990	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928
<b>2.2 Урт хугацаат</b>	78	75	71	68	69	68	68	68
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	75 3	75 0	71 0	68 68	69 69	68 68	68 68	68 68
<b>3. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)</b>	<b>1,074</b>	<b>1,298</b>	<b>1,629</b>	<b>1,579</b>	<b>2,102</b>	<b>1,856</b>	<b>2,045</b>	<b>2,061</b>
<b>3.1 Богино хугацаат</b>	58	200	315	290	277	223	331	353
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	58	200	315	290	277	223	331	353
<b>3.2 Урт хугацаат</b>	1,016	1,098	1,314	1,289	1,825	1,633	1,714	1,707
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	142 495 379	160 351 586	140 473 701	104 472 713	151 959 715	140 668 825	182 649 883	229 643 835
<b>4. Бусад салбарууд</b>	<b>1,856</b>	<b>2,633</b>	<b>3,522</b>	<b>3,446</b>	<b>3,574</b>	<b>3,510</b>	<b>3,501</b>	<b>3,568</b>
<b>4.1 Богино хугацаат</b>	508	406	562	486	453	421	409	408
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	288 221	233 173	259 303	261 226	271 180	246 173	239 167	237 168
<b>4.2 Урт хугацаат</b>	1,348	2,228	2,960	2,960	3,121	3,088	3,093	3,161
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	581 735 31	584 1,305 339	847 1,822 291	847 1,901 212	851 1,912 358	831 1,976 282	808 1,982 302	859 1,994 307
<b>5 Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг</b>	<b>8,357</b>	<b>10,341</b>	<b>10,615</b>	<b>10,528</b>	<b>10,517</b>	<b>10,472</b>	<b>10,676</b>	<b>10,850</b>
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг Хамааралтай компани хоорондын өглөг	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850
<b>Нийт гадаад өр</b>	<b>15,386</b>	<b>19,022</b>	<b>20,942</b>	<b>20,985</b>	<b>21,785</b>	<b>21,590</b>	<b>21,829</b>	<b>22,599</b>

Эх сурвалж: Монголбанк